



БАНГАУУР ДҮҮРГИЙН
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН
БАЙДАЛ


БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2026 8 сар

www.ubstat.mn

[www.facebook.com/Багануур дүүргийн Статистикийн хэлтэс](https://www.facebook.com/Багануур-дүүргийн-Статистикийн-хэлтэс)

www.1212.mn



АГУУЛГА

Хуудасны
дугаар

	ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2022-2026 ОН	3
	БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	4
	НИЙГМИЙН ДААТГАЛ	5
	НИЙГМИЙН ХАЛАМЖ	7
	ЭРҮҮЛ МЭНД	8
	ГЭМТ ХЭРЭГ	10
	ҮНЭ ХАНШ	13
	АЖ ҮЙЛДВЭР	17
	НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	18

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭСТ, МАЛЫН ТӨРӨЛ, ХОРООГООР

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	165 796	36 969	7 184	34 740	52 143	34 760
Үүнээс:						
Тэмээ	42	15	-	24	-	3
Адуу	21 685	5 837	1 083	4 670	5 048	5 047
Үхэр	22 930	5 731	1 634	4 944	6 121	4 500
Хонь	70 597	14 707	2 660	14 871	24 294	14 065
Ямаа	50 542	10 679	1 807	10 231	16 680	11 145

ХҮСНЭГТ 2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний VIII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	I-VIII				
		2022	2023	2024	2025	2026
Суурин хүн ам	тоо	29 341	28926	29152	28949	-
Төрөлт	тоо	359	376	318	275	280
Нас баралт	тоо	121	104	107	102	128
Шилжиж ирсэн	тоо	576	530	583	672	1156
Цэвэр өсөлт	хувь	0.81	0.94	0.72	0.60	0.53'

'өмнөх оны суурин хүн амаас тооцов.

ЗУРАГ 1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, 2025 ОН






БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД

Дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст 106 иргэн идэвхтэй ажил хайж бүртгүүлсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 41 (1.6 дахин) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 8 дугаар сард, тоогоор




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 28 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 15 (53.6%) нь эмэгтэйчүүд эзэлж байгаа ба дараах шалтгаанаар нэмэгдсэн

байна. Мөн энэ хугацаанд 5 иргэн ажилд зуучлуулан орж, 30 иргэний бүртгэл идэвхгүй болсон байна.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, ШАЛТГААНААР, 8 дугаар сард, тоогоор



ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, тоо, хувиар



Тайлант сард ажил хайж байгаа иргэдийн 11 (10.4%) нь 15-24 насны, 22 (20.8%) нь 25-34 насны залуучууд, 49 (46.2%) нь 35-44

насныхан, 23 (21.7%) нь 45-60 насныхан, 1 (0.9%) нь 60+ насныхан эзэлж байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролоор, 8 дугаар сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Үүнээс: эмэгтэй		
	2024	2025	2026	2024	2025	2026
	тоогоор					
Ажилгүйчүүд, бүгд	53	65	106	33	30	66
Үүнээс:						
Дээд боловсролтой	24	24	27	16	16	19
Тусгай дунд боловсролтой	2	3	4	1	-	3
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	2	4	5	1	1	2
Ерөнхий боловсролтой	25	31	69	15	13	41
Бага болон боловсролгүй	-	3	1	-	-	1

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 24 (25.5%) нь дээд боловсролтой, 4 нь (3.8%) тусгай дунд, 5 нь (4.7%) мэргэжлийн анхан шатны боловсролтой, ерөнхий боловсролтой

иргэд 69 (65.1%), бага болон боловсролгүй иргэн 1 (0.9%) ажээ. Ажил хайгч иргэдийн 66 (62.3%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын сангийн орлого 26.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.8 (11.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 21.7 (81.2%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 2.3 (8.6%) тэрбум төгрөг тэтгэмжийн сангаас, 1.9 (7.1%) тэрбум төгрөг үйлдвэрлэлийн осол,

мэргэжлээс шалтгаалах өвчний сангаас, 821.1 (3.1%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.


ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сараар



ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, эхний VIII сард

Үзүүлэлт	I-VIII			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	дүн	хувь
	сая төгрөг				
Сангийн орлого, бүгд	38 922.6	23 863.5	26 663.8	2 800.3	11.7
тэтгэврийн сан	35 011.6	19 377.6	21 657.9	2 280.3	11.8
тэтгэмжийн сан	1 336.6	2 064.4	2 298.2	233.8	11.3
ҮОМШӨ ¹ -ний сан	1 784.2	1 693.1	1 886.6	193.5	11.4
Ажилгүйдлийн сан	790.2	728.4	821.1	92.7	12.7
Сангийн зарлага, бүгд	38 543.1	45 213.6	51 671.1	6 457.5	14.3
тэтгэврийн сан	34 569.6	40 685.2	45 677.5	4 992.3	12.3
тэтгэмжийн сан	1 469.7	1 872.0	2 360.7	488.7	26.1
ҮОМШӨ ¹ -ний сан	1 735.8	1 741.0	1 934.4	193.4	11.1
Ажилгүйдлийн сан	768.0	915.4	1 698.5	783.1	85.5

ЗУРАГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, сая төгрөг



Сангийн зарлага 51.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6.5 (14.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд тус сангаас 5397 хүнд 45.7 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 1253 хүнд 2.4 тэрбум төгрөгийн тэтгэмж, 358 хүнд 1.9

тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 291 хүнд 1.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.

¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 891.4 (6.7%) сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 536 хүнд 1.9 тэрбум төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 509 хүнд 1.3 тэрбум төгрөгийн асаргааны тэтгэмж, 312 хүнд 531.8 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 360 жирэмсэн

эхэд 43.5 сая төгрөгийн тэтгэмж, 10974 хүүхдэд 8.5 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асардаг 1085 эцэг, эхэд 327.0 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон байна.

ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРДАЛ, эхний VIII сард

Үзүүлэлт	I-VIII			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	дүн	хувь
	сая төгрөг				
Сангийн зарлага	12 479.4	13 226.5	14 117.9	891.4	6.7
Тэтгэвэр	1 304.4	1 481.1	1 872.8	391.7	26.4
Тэтгэмж	864.7	1 059.4	1 293.7	234.3	22.1
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	329.0	384.2	531.8	147.6	38.4
"Алдарт эх" 1 одонтой Эхчүүд	110.4	217.0	215.2	- 1.8	- 0.8
"Алдарт эх" 2 одонтой эхчүүд	180.6	373.6	386.0	12.4	3.3
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	50.1	47.5	43.5	- 4.0	- 8.4
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	8 493.7	8 562.5	8 499.1	- 63.4	- 0.7
0-3 хүртэлх настны хүүхэд асаргааны тэтгэмж	397.3	356.4	327.0	- 29.4	- 8.2
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	176.4	197.7	340.1	142.4	72.0
ХБИргэнд үзүүлсэн хөнгөлөлт	15.7	21.0	26.0	5.0	23.8
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	100.1	95.2	53.9	- 41.3	- 43.4
Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж	88.5	104.7	123.3	18.6	17.8
Оршуулгын тэтгэмж	20.0	18.0	24.0	6.0	33.3
Ихэр хүүхдийн тэтгэмж	4.8	10.8	10.0	- 0.8	- 7.4
Онцгой тохиолдлын тэтгэмж	2.8	-	8.4	8.4	-
АДЗГ урамшуулал	62.3	-	-	-	-
ОНОТХҮйлчилгээ	-	-	44.2	44.2	-
Насны хишиг	278.6	297.4	318.9	21.5	7.2

Мөн 1150 ахмад настанг 340.1 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламжинд, 604 өрхийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 53.9 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 74 иргэдэд 26.0 сая

төгрөгийн хөнгөлөлт, өрх толгойлсон 86 эцэг эхэд 123.3 сая төгрөгийн тэтгэмж, 2137 иргэнд 318.9 сая төгрөгийн насны хишиг, 8 иргэнд 24.0 сая төгрөгийн

оршуулгын тэтгэмж, 5 иргэнд 10.0 сая төгрөгийн ихэр хүүхдийн тэтгэмж, 7 иргэнд 8.4 сая төгрөгийн онцгой тохиолдлын тэтгэмжийг тус тус олгожээ.



ЭРҮҮЛ МЭНД

Гар, хөл амны өвчний 366 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний (58.5%) эзэлж байна.

2026 оны эхний 8 сарын байдлаар бэлгийн замын халдварт өвчний 52 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 8.5%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 16 (23.5%) тохиолдлоор буурсан бол, цочмог халдварт өвчний 574 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний

91.5%-ийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 152 (36.0%) тохиолдлоор өссөн байна.


Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 215.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 46.8 продицмиллээр өссөн байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, эхний VIII сард


Үзүүлэлт	I-VIII			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	дүн	хувь
Нийт халдварт өвчин	145	490	626	136	27.8
Бэлгийн замын халдварт өвчин	79	68	52	-16	-23.5
Заг хүйтэн	40	39	43	4	10.3
Тэмбүү	26	22	9	-13	-59.1
Трихомониаз	8	5	-	-5	-100.0
Кандилом	1	-	-	-	-
Хомхой	1	2	-	-2	-100.0
Хламид	3	-	-	-	-
Цочмог халдварт өвчин	66	422	574	152	36.0
Цусан суулга	9	8	8	-	0.0
Гипатит	-	3	-	-3	-100.0
Скарлатин	-	10	11	1	10.0
Салхин цэцэг	40	98	181	83	84.7
Боом	1	-	-	-	-
Улаан бурхан	-	258	1	-257	-99.6
Рож	3	-	1	1	100.0
Хачигт рикеттиоз	-	1	-	-1	-100.0
Гэдэсний халдвар	-	6	1	-5	-83.3
Гар хөл амны өвчин	-	23	366	343	14.9 ¹
Сүрьеэ	13	15	5	-10	-66.7

¹-дахин их

ЗУРАГ 7. ХАЛДВАРТ ӨВЧИН, сараар



ЗУРАГ 8. ЭМНЭЛГИЙН НИЙТ ҮЗЛЭГ, эхний VIII сард



ХҮСНЭГТ 7. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, эхний VIII сард

Үзүүлэлт	I-VIII			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	дүн	хувь
Амаржсан эхийн тоо	320	306	306	0.0	0.0
Үүнээс бусад аймгийн харьяат	104	114	102	-12.0	-10.5
Амьд төрсөн хүүхэд	319	305	308	3.0	1.0
Үүнээс бусад аймгийн харьяат	103	115	104	-11.0	-9.6
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	6	4	4	0.0	0.0

Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний 8 сарын байдлаар 308 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 3 (1.0%) өссөн байна. Энэ хугацаанд 155.4 мянган хүн эмнэлгийн үзлэгт хамрагдсан нь өмнөх

оны мөн үеэс 6.6 (4.4%) мянган хүнээр өссөн бол, хэвтэн эмчлүүлсэн 4.6 мянган хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.0 (18.1%) мянган хүнээр буурсан байна.



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд оны эхний 8 сард 265 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 (3.3%) хэргээр, илрүүлэлт 48.0 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.3 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 8. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, эхний VIII сард, төрлөөр

Хэргийн төрөл	I-VIII			Өөрчлөлт	
	2024	2025	2026	тоо	хувь
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	202	274	265	-9	-3.3
Хүнийг алах	5	1	1	0	0.0
Хүний амь нас хохирсон	1	3	-	-3	-100.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	80	93	104	11	11.8
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	6	14	12	-2	-14.3
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	-	1	2	1	100.0
Бусдын эд хөрөнгө хулгайлах	32	39	30	-9	-23.1
Залилан мэхлэх	28	48	30	-18	-37.5
Дээрэмдэх	-	4	1	-3	-75.0
Мал хулгайлах	1	-	-	0	-
Хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших	19	5	5	0	0.0
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх	1	5	6	1	20.0
Хууль бусаар нийгмийн халамж үйлчилгээ авах	1	-	-	0	-
Эдийн засгийн гэмт хэрэг	6	3	1	-2	-66.7
Мөрийтэй тоглоом зохион байгуулах	1	-	-	0	-
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	2	-	3	3	-
Автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явах	1	1	4	3	4.0 ¹
Хууль бусаар мод бэлтгэх	-	-	1	1	-
Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг	2	-	-	0	-
Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах	-	1	1	0	0.0
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	1	-	1	1	-
Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэнд оруулах	-	-	1	1	-
Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг	1	2	24	22	12.0 ¹
Цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих	-	-	1	1	-
Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	16	52	37	-15	-28.8
Давтан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон	-	44	28	-16	-36.4
Замын осол	-	8	9	1	12.5
Хэрэг илрүүлэлтийн хувь	62.2	48.3	48.0		

¹-дахин их


ЗУРАГ 9. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар




Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 104 (39.3%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 30 (11.3%) нь бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг, 30 (11.3%) нь залилан мэхлэх хэрэг, 28 (10.6%) нь давтан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хэрэг, 24 (9.1%) нь цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг хэргүүд тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг хэрэг 12

(4.5%), замын осол 9 (3.4%), бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх үрэгдүүлэх хэрэг 6 (2.3%), хөрөнгө завших, гээгдэл эд зүйл завших хэрэг 5 (1.9%), автотээврийн хэрэгсэл зөвшөөрөлгүй авч явсан хэрэг 4 (1.5%), мансууруулах эм сэтгэцэт нөлөөт эм бодисыг хууль бусаар ашигласан хэрэг 3 (1.1%), хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг хэрэг 2 (0.7%), бусад хэргүүд тус бүр 1 (3.0%) бүртгэгдсэн байна.


ЗУРАГ 10. СОГТУУГААР БОЛОН ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



ЗУРАГ 11. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний VIII сард




ЗУРАГ 12. ГУДАМЖ ТАЛБАЙД БОЛОН СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эхний VIII сард



ХҮСНЭГТ 9. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮМҮҮС, эхний VIII сард

Үзүүлэлт	I-VIII			Өөрчлөлт	
	2024	2025	2026	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	145	167	168	1	0.6
Үүнээс: эмэгтэйчүүд	25	23	27	4	17.4
хүүхэд	11	13	18	5	38.5
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	189	236	236	0	0.0
Үүнээс: нас барсан	6	7	5	-2	-28.6
гэмтсэн	90	106	118	12	11.3
Согтуугаар зөрчил гарган саатуулагдсан хүний тоо	189	184	198	14	7.6
Баривчлагдсан хүний тоо	69	80	96	16	20.0
Учирсан хохирол /сая төгрөг/	415.7	837.7	501.1	-336.6	-40.2
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	174.9	199.3	162.1	-37.2	-18.7

ЗУРАГ 13. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ИРГЭД, хувиар, оны эхний VIII сард



2026 оны эхний 8 сарын байдлаар 168 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 27 (16.1%) нь эмэгтэйчүүд, 18 (10.7%) нь 18 хүртлэх насны хүүхэд тус тус бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд 236 иргэн гэмт хэргийн улмаас хохирсны 118 (50.0%) нь гэмтсэн иргэд бөгөөд нас барсан иргэн 5 (3.0%) бүртгэгдсэн байна.

Мөн 198 иргэн согтуугаар зөрчил гарган саатуулагдаж, 96 иргэн баривчлагдсан нь өмнөх оноос согтуугаар зөрчил гарган саатуулагдсан иргэд 14 (7.6%)-оор, баривчлагдсан иргэд 16 (20.0%) нэгжээр тус тус нэмэгдсэн байна.


Гэмт хэргийн улмаас 501.1 сая төгрөгийн хохирол учирсны 162.1 (32.3%) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.



ҮНЭ ХАНШ

Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.


ЗУРАГ 14. “АЛТАН ТАРИА” ГУРИЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VIII сард



ХҮСНЭГТ 10. ХҮНСНИЙ БАРААНЫ ҮНИЙН АЖИГЛАЛТ, VIII сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжих нэгж	8.07	8.14	8.21	8.28
"Алтан тариа" гурил	Дээд	кг	3 850	3 850	3 850	3 850
	I зэрэг	кг	2 650	2 650	2 650	2 650
	II зэрэг	кг	1 725	1 725	1 725	1 725
Будаа	цагаан	кг	3 900	3 900	3 900	3 900
	шар	кг	3 200	3 200	3 200	3 200
Хонины мах	ястай	кг	22 000	22 000	22 000	22 000
	цул	кг	27 000	27 000	27 000	27 000
Үхрийн мах	ястай	кг	30 000	30 000	30 000	29 000
	цул	кг	35 000	35 000	35 000	33 000
Адууны мах, ястай		кг	18 500	18 500	18 500	18 500
Ямааны мах		кг	21 000	21 000	21 000	21 000
Элсэн чихэр		кг	4 250	4 250	4 250	4 250
Сүү /задгай/		л	2 500	2 500	2 500	3 000
Тараг /задгай/		л	3 000	3 000	3 000	3 500
Цөцгийн тос, Орос		кг	6 000	6 000	6 000	6 000
Байцаа		кг	2 500	2 500	2 500	2 000
Манжин		кг	3 500	2 500	2 500	2 500
Төмс	монгол	кг	2 500	2 500	2 000	2 000
Лууван	монгол	кг	2 500	2 500	2 500	2 500
Сонгино	хятад	кг	2 500	2 500	2 500	2 500
	монгол	кг	3 000	3 000	3 000	3 000
Сармис, булцуу		ш	650	650	650	650
Огурцы, хятад		кг	5 000	6 000	7 000	7 500
Помидор, хятад /үрлэн/		кг	7 000	7 000	6 500	6 500
Ургамлын тос/ siesta/		ш	10 000	10 000	10 000	10 000
Өндөг		ш	580	580	580	580
Атар талх		ш	2 700	3 000	3 000	3 000

ЗУРАГ 15. НЭГ КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн VIII сард



ХҮСНЭГТ 11. ЦАХИЛГААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф
1. Айл өрхийн цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	184.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц	төг/квт.ц	269.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	299.0
Хоёр тарифт тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээ		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	191.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	154.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	236.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	168.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	278.0
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	168.0
Гурван тарифт тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц-аас ихгүй хэрэглээ		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	179.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	294.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	119.0
Сарын нийт хэрэглээний 151-300 кВт.ц		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	200.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	305.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	119.0
Сарын нийт хэрэглээний 300 кВт.ц-аас дээш		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	232.0
Оройн хэрэглээ /17.00-21.00/	төг/квт.ц	315.0
Шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	119.0
Сарын суурь тариф	төг/сар	3 360
2. Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгааны тариф		
Энгийн тоолууртай	төг/квт.ц	278.0
Гурван тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	278.0
Оройн хэрэглээ /17.00-22.00/	төг/квт.ц	417.0
Шөнийн хэрэглээ /22.00-06.00/	төг/квт.ц	168.0

*2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс мөрдөж буй тариф

ХҮСНЭГТ 12. ТҮЛШ ШАТАХУУНЫ ҮНЭ

Шатахууны нэр төрөл	2022 VIII	2023 VIII	2024 VIII	2025 VIII	2026 VIII
	төгрөг				
АИ -92	2 440	2 440	2 440	2 640	3 100
Дизель түлш	3 740	3 590	3 990	3 240	4 725

2026 оны 8 сард АИ-92 бензин 3100 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 460 (17.4%) төгрөгөөр, дизель түлш 4725 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1485 (45.8%) төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 13. ДУЛААНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Ангилал		Хэмжих нэгж	Тариф	
Орон сууцны халаалт		төг/м ²	845	
(Оюутны байр, подвол, “0”-ын өрөөний халаалт хамаарна)		төг/ГДж	11 150	
Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Хүний тоогоор	Халаалтын улиралд	төг/хүн	4 049
		Халаалтын бус улиралд	төг/хүн	5 668
		Усны зарцуулалтаар	төг/м ³	2 089
	Ахуйн хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тариф			
40м2 хүртэл талбайтай айл өрх		төг/сар	4 224	
41м2-аас 80м2 хүртэл талбайтай айл өрх		төг/сар	7 040	
81м2-аас дээш талбайтай айл өрх		төг/сар	14 080	
Үйлдвэр, аж ахуйн нэгжийн дулааны эрчим хүчний тариф				
Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт		төг/м ³	1 487	
		төг/ГЖ	23 767	
Багануур ХК-ийн халаалт		төг/ГЖ	33 234	
		төг/м ³	1 549	
Төсвийн байгууллагын халаалт		төг/ГЖ	29 693	

ХҮСНЭГТ 14. УСНЫ ҮНИЙН ТАРИФ, (НӨАТ-гүй үнэ)

Үзүүлэлт		Хэмжих нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)	3 162	1 гкал	84 272
		1м³(тоолууртай)	1 632		
	Зун	1 хүн (тоолуургүй)	4 428		
		1м³(тоолууртай)	1 632		
Цэвэр ус ²		1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0
		1 л (тоолууртай)	1.5		
		Ус түгээх байраар	2.72		
Бохир ус ²		1 хүн (тоолуургүй)	1.8	1 л (тоолууртай)	3.5-5.0
		1 л (тоолууртай)	1.5		
		Ус соруулах	15.0		



АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 168.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (0.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, сая төгрөгөөр

Үзүүлэлт	I-VIII			Өөрчлөлт	
	2024	2025	2026	дүн	хувь
Нийт дүн	137 336.2	169 848.9	168 262.7	-1 586.2	-0.9
Нүүрс олборлолт	129 321.5	160 433.5	157 675.9	-2 757.6	-1.7
Дулаан дамжуулалт	6 088.9	6 404.9	7 300.5	895.6	14.0
Талх, нарийн боов	737.1	889.6	1 060.1	170.5	19.2
Зайлуулсан хог хаягдал	1 188.7	2 120.9	2 226.2	105.3	5.0


ХҮСНЭГТ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, биет хэмжээгээр

Үзүүлэлт	I-VIII			Өөрчлөлт	
	2024	2025	2026	дүн	хувь
Нүүрс олборлолт, мян.тонн	2 985.9	2 942.6	2 961.0	18.4	0.6
Дулаан дамжуулалт, мян.гкал	107.0	101.6	113.1	11.5	11.3
Талх, нарийн боов, тонн	185.8	175.7	159.0	-16.7	-9.5
Зайлуулсан хог хаягдал, мян.м3	41.2	40.3	47.4	7.1	17.6


Тайлант хугацаанд нүүрс олборлолт өнгөрсөн оны мөн үеэс 18.4 (0.6%) мянган тонноор өсч, үнийн дүнгээр 2.8 (1.7%) тэрбум төгрөгөөр буурсан бол дулааны эрчим хүч үйлдвэрлэл 11.5 (11.3%) мянган гкал-аар буюу 895.6 (14.0%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Талх нарийн боовны

үйлдвэрлэлт өнгөрсөн оноос 16.7 (9.5%) тонноор буурч, үнийн дүнгээр 170.5 (19.2%) сая төгрөгөөр нэмэгдсэн бол, зайлуулсан хог хаягдлын хэмжээ 47.4 мянган метр куб болж өмнөх оноос 7.1 (17.6%) мянган метр куб-ээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


ЗУРАГ 16. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, сараар, сая төгрөг



ЗУРАГ 17. ТАЛХ, НАРИЙН БООВ ҮЙЛДВЭРЛЭЛТ, сараар, сая төгрөг



ЗУРАГ 18. НҮҮРС ОЛБОРЛОЛТ, жил бүрийн эхний VIII сард, мянган тонн




НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийтийн үйлчилгээний орлого 3047.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 258.9 (9.3%) сая төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 17. ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ОРЛОГО, эхний VIII сард

Үзүүлэлт	I-VIII			Өсөлт бууралт	
	2024	2025	2026	тоо	хувь
	сая төгрөг				
Нийт орлого	2 572.2	2 788.3	3 047.2	258.9	9.3
Орон сууц	453.9	470.4	643.0	172.6	36.7
Ус борлуулалт	1 042.0	1 086.4	1 079.4	-7.0	-0.6
Сувагжуулалт	928.2	968.1	953.6	-14.5	-1.5
Бусад	148.1	263.4	371.3	107.8	40.9

ЗУРАГ 19. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, сараар, сая төгрөг



ХҮСНЭГТ 18. СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБООДЫН ОРЛОГЫН БИЕЛЭЛТ, эхний VIII сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөөний биелэлт
	сая төгрөг		
Нийт дүн	631.2	596.0	94.4
Тавлаг өргөө	134.3	124.4	92.6
Маргад өргөө	101.4	130.3	128.5
Сод хөгжил	129.4	110.7	85.6
Шинэ элч	131.2	115.7	88.2
Уурхайчин	66.5	57.5	86.5
Содон суварга	68.6	57.4	83.8

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 оны 9 дүгээр сарын 14

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 



аппликейшнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab | тооллого судалгааны микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/

 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn